Щщ	ъ	ы	ь	Ээ	Юю	Яя

3. Зөвхөн эгшиг үсэг бичсэн шоог сонгож, тэмдэглэе.



2. Өөрийнхөө овог нэрийг бичье.



Чиний аав хэн бэ?  
Чиний нэр хэн бэ?


Миний овог: \_\_\_\_\_

Миний нэр: \_\_\_\_\_

Миний овог Ням.  
Миний нэр Маргад.



Цэвэр сайхан бичиж суръя.



1. Дармал ба бичмэл үсгийг харьцуулан ажиглая.
2. Гийгүүлэгч үсгийг дугуйлж тэмдэглэе.
3. Өөрийнхөө сурч байгаа сургууль, ангиа бичье.

Говь-Алтай  
аймгийн Дарви  
сумын бүрэн  
дунд сургууль



Манай сургууль:


Манай анги:

Үлгэрийг ойлгож уншъя.

## Загасчин муур



1. Нэгэн муур загас барихаар гол руу явжээ.



2. Дэгээгээ шидээд удаан хүлээж гэнэ.



3. Эхлээд нэг загас барилаа. Хадран загас байв. “Жижигхэн загас” гэж муур голжээ.



4. Дэгээндээ дахин чийгийн улаан хорхой хийв.

Утгыг мэдье

хадран, алгана, цурхай



5. Тэгээд дэгээгээ шидтэл алгана загас баригдав.



6. Муур “Алгана ч бас жижигхэн загас” гэж голоод дахин дэгээгээ усанд шидэв.



7. Харин энэ удаа муурын дэгээнд том цурхай загас оржээ.




8. Гэтэл муур цурхай загасанд татагдан усанд унажээ.



Уншсанаа ярилцъя

-Муур ямар ямар загас барьсан бэ? Дугаарлаарай.



Зөв бичье

идүүлье, аюулаас

## ЦАГААН ТОЛГОЙ

А, э, и, о, у, ө, ү  
Алтан номын тулгуур аа  
А, э, и, о, у, ө, ү  
Оюун ухааны шалгуур аа  
На, нэ, ни, но, ну, нө, нү  
Үеэр уншиж мэдлээ дээ  
Наран, Саран, Цолмон гээд  
Нэрээ бичиж сурлаа даа  
Ма, мэ, ми, мо, му, мө, мү  
Үеэр уншиж мэдлээ дээ  
Монгол, Чингис, Мандухай  
Удмаа бичиж сурлаа даа

Т.Галсан

### 1. Үе нийлүүлж үг бүтээн бичье.

би эр ү мэд сэг чиг лэг дэм

Handwriting lines for practicing the words.

### 2. Аймаг, сумынхаа нэрийг бичье.

Би .....  
аймгийн .....  
суманд амьдардаг.

Би .....  
хотын .....  
дүүрэгт амьдардаг.

Тод, чанга уншиж суръя.

## Багш аа! Би би

Цэвэрхэн бичсэн шүлгээ  
Цээжээр уншъя, Би би  
Шинэхэн сурсан дуугаа  
Шимтэн дуулъя, Би би  
Багш аа, багш аа! Би би  
Уншиж мэдсэн үлгэрээ  
Утгыг ярья, Би би  
Урлан зурсан зургаа  
Учрыг нь хэлье, Би би  
Багш аа, багш аа! Би би



Ү.Хүрэлбаатар

### 1. Тохирох үгийг нөхөж бичье.

...	уншъя	...	ярья
...	дуулъя	...	хэлье

аа оо өө уу үү ий ы



### 3. Цэгийн оронд тохирох урт эгшгийг сонгож бичье.

1. х...хэд	(уу)	_____
2. балл...р	(ээ)	_____
3. харанд...	(оо)	_____
4. цонх...р	(аа)	<u>цонхоор</u>
5. шир...	(үү)	_____

Ойлгож уншъя.



## Муухай бичдэг үзэг

Болор, Болд хоёр нэг ширээнд суудаг. Болд хэчнээн хичээвч Болор шиг сайхан бичиж чадахгүй байв. Нэг удаа Болд:

- Үзгээ өгөөч, би ганцхан биччихээд өгье! гэтэл Болор:
- Өөрийнхөө үзгээр бичихгүй яагаа вэ? гэв. Болд түүний сайхан бичгийг харж, санаа алдсанаа:
- Миний үзэг даанч муухай бичээд байх юм даа гэж гэнэ.



Уншсанаа ярилцъя

- Болд яагаад Болороос үзгийг нь гуйсан бэ?
- Болд, Болорын үзгээр түүн шиг сайхан бичиж чадах болов уу?




Чадна, Учир нь ...

Чадахгүй, Учир нь ...

1. Амьтдын нэрийн эхний үсгийг ашиглан оньсогыг таая.

**Оньсого**  
Цангаг ангаг зантай  
Цагаан газар явдалтай



ай

ой

эй

уй

үй

2. Эх ба оньсогоос хос эгшигтэй үгийг олж бичээрэй.

**Зөв бичье**

биччихээд, алдсанаа





Зөв, тод чанга уншъя.

## Номын нөхөр

...Аян замд дотно нөхөр  
Амьдрал турш мэргэн багш  
Ном ном уншаарай  
Номын нөхөр болоорой  
Эрдмийн далай эрчит сэлүүр  
Хүслийн тэнгэрт хүчит жигүүр  
Ном ном уншаарай  
Номын нөхөр болоорой


Ж.Дашдондог



Уншсанаа ярилцъя

- Яагаад номыг багш гэсэн бэ?

1. Номын нэрийг уншаарай. Уншсан номынхоо тухай найздаа ярь.



- Зохиолч нь хэн бэ?

- Ямар нэртэй ном бэ?

2. Асуултад хариулж бичье.

Handwriting practice lines consisting of three sets of horizontal lines with a dashed midline and a solid top and bottom line. Each set is separated by a vertical line.

3. Холбоо үг бүтээж, өгүүлбэрийг гүйцээе.

буддаг  
үлгэрийн  
зурагтай  
.....



Надад ..... ном олон бий.

Миний дүү ..... ном үзэх дуртай.

Ээж ..... ном авчирлаа.

Ойлгож уншъя.

## Цэцэг тарьсан нь


Цэрмаа Цэндтэй уралджээ  
Цэцэг тарихаар шийджээ  
Анги ангийнхаа цонхон дээр  
Адилхан саванд суулгажээ  
Цэцгээ ургуулахын төлөө  
Цэрмаа их ажиллажээ  
Өдөр болгон үзээд л  
Өнжөөд л усалдаг байжээ  
Цэцгээ ургуулахын төлөө  
Цэнд ер хайхарсангүй  
Чийггүй шороо саванд нь  
Чигжирч бүр хатчихжээ

Д.Содномдорж




Уншсанаа ярилцъя

- Яагаад нэг цэцэг нь ургаж, нөгөө нь ургаагүй вэ?
- Цэцэг хэрхэн арчилдаг талаар ярилцаарай?
- Хэний тарьсан цэцэг вэ? Нэрийг нь бичнэ үү.



Өгүүлбэр бүтээж уншъя.






Цаасан шувуу  
Ямар нэм муухай вэ?  
Чи мэдэгч муухай  
Юу сайхан бэ?  
Саруул ухаан сайхан  
Юу хорттой вэ?  
Өст сэтгэл хорттой  
Юу тустай вэ?  
Сайхан сэтгэл тустай



1. Шүлгийг цээжилье. Өвөө хүү хоёрыг төлөөлөн уншъя.
2. Үгсийг ашиглан зүйр цэцэн үг бүтээж бичье.



Сайныг дагавал сарны гэрэл

Утгыг мэдье

үл мэдэгч, өст сэтгэл, саруул ухаан

## Шуурга


Толя нэгдүгээр ангид сурдаг. Түүнийг гэрээсээ гарахад цасан шуурга шуурч байв. Толя айн, улиасны доор зогсов. Тэгээд хартал нарс модны дор Саша зогсож байв. Тэр бас л айгаад сургууль руугаа явж чадахгүй байжээ. Хөвгүүд бие биеэ хараад баяр хөөр болов. Тэд сургууль руугаа хамт гүйлээ. Шуурга исгэрэн шуугивч, аймаар биш байлаа.

В.А.Сухомлинский

Уншсанаа ярилцъя



### 1. Тохирох үгийг сонгоорой.




А. Тэд сургууль руугаа ..... гүйлээ.

Б. Шуурга исгэрэн шуугивч, ..... биш байлаа.

### 2. Зүйр цэцэн үгийн утгыг ярилцаад бичье, тогтооё.

Олон хүчтэй

Үнэн ачтай



### 3. Загварын дагуу өгүүлбэр зохиож бичье.

Хөвгүүд гүйв.

а.   .

б.    .

### 4. Үгсийг зөв байрлуулж өгүүлбэр бүтээе.

бие биеэ

баяр хөөр

хараад,

Хөвгүүд

болов.

гүйлээ.

хамт

сургууль руугаа

Тэд

Зөв бичье

исгэрэн, шуурга, шуугивч

## Хамтын хүч

Мандах ааваасаа

- Хамтын хүч гэж юу вэ? гэж ихэд сонирхон асуулаа. Аав нь:

- Миний хүү өөрөө мэдэж аваарай гэв.

Мандахын ангийнхан сургуулийнхаа хашааны цас цэвэрлэв.

Зарим нь цасыг хүрээр овоолон, бусад нь тэр цасыг чаргаар зөөлөө. Хүүхдүүд их л урамтай, хөгжилтэй ажиллав. Ажлаа дууссаны дараа багш нь

- Бид ганц хүний олон өдөр хийх ажлыг маш хурдан хийлээ. Энэ бол хамтын хүч юм шүү дээ гэв. Ийнхүү Мандах хамтын хүчийг өөрөө мэдэж авлаа.

1. Хамтын хүчээр юу, юу хийж болохыг ярилцъя.

мод тарих

.....

.....

.....

2. Үгс, зургийг ашиглан өгүүлбэрийг гүйцээгээрэй.

Хулан

ус

Билгүүн

хөрс

хамтын хүч



### Мод тарив

Манай ангийнхан мод тарив. .... модны .....-ийг бэлтгэв. .... мод услах ..... авчрав. Бид .....-ээр мод тарилаа.

3. Хоёр хүүхдийн нэрийг бичье.

Handwriting practice lines with a grid pattern for writing names.

Зөв бичье

сонирхон, дууссаны

## Ээжийн сургаал



Найрсаг хөөрхөн ааштай байвал  
Найзууд олонтой байдаг гэсэн  
Уур уцааргүй инээж явбал  
Урт насалдаг гэсэн  
Эрдэм ном их сурвал  
Эрхэм баян тэр гэсэн  
Ээж надад ингэж захисан  
Эрхэмлэн санаж яваарай гэсэн  
Д.Давааням



Уншсанаа ярилцъя

- Ээж нь юу юу гэж захидаг вэ?

1. Ямар нь муу вэ? 😞 Ямар нь сайн бэ? 😊 Зуръя.

нөхөрсөг



тусч



ууртай



харамч



худалч



үнэнч, шударга



2. Үгсийг байрлуулж сургаал үг бүтээе.

Аавын

алт

Ээжийн

сургаал

сургаал

эрдэм

Зөв бичье

өглөгч-харамч шударга-зальтай  
тусархаг-амиа бодогч

## Улаан үнээ

Ихбаяр, Хосбаяр хоёр хааяа тугал сүүлдэн тоглож, өвөөдөө зэмлүүлдэг байв. Нэг өдөр их сүүтэй улаан үнээ нь зэлэн дээр ирээд удтал мөөрөв. Энэ байдлыг гайхан харж байсан Хосбаяр:

- Эмээ ээ, улаан үнээ юу гэж мөөрөөд байгаа юм бол? гэж асуухад:

- Тугалыг минь сүүлдэж тоглоод байвал сүүгээ өгөхгүй шүү гэж байна гээд ач хүүгээ өхөөрдөн харжээ.



Д.Оюунсүрэн

### 1. Асуулт зохиож суръя.

- Хоёр хүү яагаад өвөөдөө ..... ?
- Их сүүтэй улаан үнээ ..... ?
- Хосбаяр ..... ?
- Эмээ нь ..... ?

### 2. Тохирох үгсийг холбоё.

юу?	яав?
Тугал	саав.
Үнээ	хөөрөв.
Эмээ	хөхөв.
Сүү	мөөрөв.

### Өөрсдөө жишээ зохиоё.

хэн? юу?	яав?
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....

### 3. Зургийг ажиглаад 2-3 өгүүлбэр зохиож бичье.



## Харьцуулан уншиж ярилцъя.

### 1. Уншаад тохирох хэсгийг сонгоорой.

Ээж аав нь Билгүүнд шударга үнэнч байхыг үргэлж захидаг. Билгүүн нэг удаа ангиасаа гарч яваад мөнгөтэй хэтэвч олжээ. Билгүүн тэр хэтэвчийг авснаа .....



1. цүнхэндээ хийж,  
цааш алхав.

2. эзнийг нь олохоор  
гүйв.

Маргадын ангийн багш нь “Даалгавраа гүйцэд хийгээрэй” гэж байнга сануулдаг. Маргадын хичээлдээ явах цаг болоогүй, хийх даалгавар ч их байлаа. Маргад ..... гэж бодов.

1. сургууль дээрээ  
эртхэн очъё.

2. даалгавраа хийж  
дуусгаад явъя.



### 2. Зүйр цэцэн үгийг уншаад дээрх эхтэй холбон ярилцъя.

Нөхрийн хэрэг бүтвэл  
Өөрийн хэрэг бүтнэ

Давс хийвэл уустал  
Ажил хийвэл дуустал



## Бэлгэтэй сайхан үгс

Би зун хөдөө явж, өвөөгийн дөө очиж амрав. Өвөө намайг саахалтын айлаар дагуулж явлаа. Доной гуай гэрийнхээ гадаа хонь хяргаж суув. Өвөө Доной гуайтай мэндлээд

“Хайч нь хурц

Хайчилсан хонь нь мянга түм хүрч байг” гэхэд Доной гуай хариуд нь “Мөр зохь” гэлээ.

Гэрт нь ортол Должин гуай цай самарч байв.

Өвөө маань

“Буцалсан цай чинь бурам болж

Буусан айл маань баян бол” гэв. Должин гуай “Ерөөл бат оршиг” гэж хариуллаа. Намайг хотоос авчирсан чихэр жимсээ Должин гуайд өгөхөд хоёр гардан аваад

“Уулнаас өндөр биетэй

Уснаас гүн эрдэмтэй болоорой” гэж ерөөлөө.

Би хариуд нь ..... гэж хэллээ.



- Хэн хэн юу гэж хэлсэн бэ?

1. Хэн, юу гэсэн асуултад хариулагдах үгсийг түүж бичье.

Хүн

Доной

Юм

Хайч

2. Өгүүлбэрийг дуурайн бичээрэй.

*Ерөөл бат оршиг.*

Утгыг мэдье

саахалт айл, хонь хяргах,  
мөр зохь

Зөв бичье

хариуллаа, хайчилсан

## Таван зүс

- Хурга хурга чи яагаад Хундан цагаан болсон юм бэ?
- Цасны сүүлчээр төрсөн юм чинь Цагаан болох нь аргагүй биз ээ



- Ишиг ишиг чи яагаад Хадган цэнхэр болсон юм бэ?
- Цэлмэг өглөө төрсөн юм чинь Цэнхэр болох нь аргагүй биз ээ

- Тугал тугал чи яагаад Зосон улаан болсон юм бэ?
- Ургах нарнаар төрсөн юм чинь Улаан болох нь аргагүй биз ээ



- Унага унага чи яагаад Хилэн хар болсон юм бэ?
- Харанхуй шөнө төрсөн юм чинь Хар болох нь аргагүй биз ээ

- Ботго ботго чи яагаад Алтан шаргал болсон юм бэ?
- Шаргын говьд төрсөн юм чинь Шар болох нь аргагүй биз ээ



Ж.Дашдондог



Уншсанаа ярилцъя


Цэгийн оронд тохирох үгийг эхээс олж бичье.

цэв цэнхэр	хурга
.....	.....
.....	тугал
хилэн хар	унага
алтан шаргал	.....

1. Нүдлээд хуулж бичье.

*Хурга, ишиг, тугал, унага,  
ботлыг төл мал гэнэ.*

2. Бүгдээрээ ярилцъя.



Утгыг мэдье

зос, хилэн хар

Зөв бичье

аргагүй биз ээ, говьд

Уншаад тогтооё.

## Дөрвөн бэрх

Ямаа ямаа буугаарай  
Сав дүүрэн  
Саальтай болог



Морь морь буугаарай  
Молор эрдэнэ  
Минийх болог



Хонь хонь буугаарай  
Холбоо дүүрэн  
Хоньтой болог



Тэмээ тэмээ буугаарай  
Тэрэг дүүрэн  
Ноостой болог



1.Зургийг ажиглаад өгүүлбэр зохиож бичье.

Утгыг мэдье

молор эрдэнэ, холбоо дүүрэн хонь

## Ажлын амт

Янжин гуай өглөө ямаагаа саагаад гэртээ орж, хүү Буянд аарц өгөв. Буян хэлжээ.

- Энэ яасан гашуун аарц вэ? Би ийм аарц уухгүй, амттай аарц өгөөч гэв. Янжин гуай хэлжээ.

- Одоо амттай аарц байхгүй байна. Ямаагаа хариулаад ирэхэд сайхан аарц бэлэн болно гэв. Буян ямаагаа хариулж яваад өдөр ирж

- Амттай аарц байна уу? гэхэд

- Байна аа гээд аарц өгөв. Буян түүнийг уугаад

- Яасан амттай аарц вэ? гэв. Янжин гуай ингэж хэлэв.

- Чиний өглөөний голсон аарц шүү дээ. Ажил хийвэл аарц мөн амттай болдог гэжээ.

Уншсанаа ярилцъя



- Өглөө голсон аарц нь орой яагаад амттай болсон бэ?

1. Зурагт тохирсон өгүүлбэр зохиож ярилцъя.



3. Холбоо үг бүтээж уншъя.



4. Үгийг зөв байрлуулж сургаал үг бүтээж бичье.



Зөв бичье

хариулаад, хариулж, амттай

## Ах дүү дөрөв

Эрт цагт юм гэнэ. Дөрвөн хүүтэй нэг өвгөн байжээ. Тэр дөрвөн хүү нь “Хонио хэн хариулах вэ?”, “Аргал хэн түүх вэ?”, “Тугалаа хэн харах вэ?” гэж ажил болгон дээр би чи гэж муудалцана. Үүнийг ажигласан эцэг нь:

- Тэгж болохгүй ээ. Ахаа алд хүндэл, дүүгээ дэлэм хүндэл гэдэг сургаал байдаг. Бас нэгэн үлгэр байдаг юм гээд “Эвтэй дөрвөн амьтан” үлгэрийг ярьж өглөө. Өвгөн хэдэн хүүхдээ ээлжлэн харвал отгон хүү нь

- Аав аа бид таны сургаалыг дагая. Эвтэй байя гэв. Дунд хүү нь:

- Тэгвэл бид эвтэй дөрвөн амьтад шиг амьдарч хүмүүст харуулъя гэлээ.

Тэр цагаас хойш ах дүү дөрөв ажил бүхнээ минийх чинийх гэлгүй хамжиж, хамтарч хийдэг болжээ. Нутагтаа ажилсаг сайн хүүхдүүд гэж гайхагджээ.

Г.Ловор

- Хүүхдүүд ямар болж өөрчлөгдсөн бэ?

а. залхуу

б. ажилсаг

в. эвтэй

### 1. Сургаал үгийг тодруулан бичье.

Залхуугийн гадаа түлээгүй  
Заллидгийн гэрт хоолгүй

### 2. “Эвтэй дөрвөн амьтан” үлгэрийн амьтаас аль амьтны нэр дутуу байгааг олъё.

т					
у	а				
у		г		з	
л			т	а	
а				а	
й				н	а

### 3. Эгнээ бүрд байгаа үгсийг нүдлэн уншъя.


дагая  
саная  
хайя

засъя  
харуулъя  
дуулъя

ярья  
сахъя  
тарья



Чи ямар, ямар  
улирлын нэрийг  
мэдэх вэ?



Хавар, зун  
.....

Хүүгийн хариултыг гүйцээж тусалъя.

## Дөрвөн улирал

Хүүхэд бидний  
Баяр болдог  
Хөгжөөнт зуны  
Улирал сайхан



Амтат жимсээр  
Бэлэг барьдаг  
Алтан намар  
Айдаа гоёхон



Сүлд модны  
Наадам болдог  
Сүртэй өвөл  
Бас гайхам



Зун намар өвлийн  
Зугаатай бүгдийг дуурайсан  
Содон чамин хавар маань  
Сайхан, гоёхон, гайхам

*Б.Доржсүрэн*



Уншсанаа ярилцъя

- Ямар улиралд дуртайгаа ярилцъя.

1. Хаврын улирлын тухай өгүүлсэн бадгийг сонгож бичье.

Тод, чанга уншъя.

## Тариа будаа

Тариа будаа хоёрыг  
Тарьж ургуулдаг юм  
Тарьсан хойноо  
Түүнийг хурааж авдаг юм  
Тансаг сайхан тариагаа  
Гурил болгон тээрэмдээд  
Та бидний иддэг  
Талх боовыг хийдэг юм  
О.Цэндсүрэн



Уншсанаа ярилцъя

Талх яаж бүтдэг дарааллыг ярилцъя.

Тариа будаа хоёрыг  
Тарьж ургуулдаг юм

1

3

2

4

1. Үгийг сайн нүдлэн уншаад, зурагтай холбоё.


тахиа

тариа

захиа

бариа

нахиа



2. Сургаал үгийг гүйцээж бичье.

Мах идье гэвэл

малла

Талх идье гэвэл

тарь



## Цастай хамт ирсэн найз



1

Цас оржээ. Хүү цасаар тоглов.



2

Хүү цас өнхрүүлээ.



3

Цас өнхөрсөөр улам бүр томорч байв.



4

Тэр цасаар том бөмбөг хийлээ.



5

Дахин нэг цасан бөмбөг хийлээ.



6

Тэгээд гэрээсээ лууван авчрав.



7

Бас нэг модны мөчир олж ирэв.



8

Ороолт малгайгаа ч өмсгөв.



9

Хүү өөрийн найзаа бүтээжээ.



Уншсанаа ярилцъя

1. Хүү өөрийнхөө найзыг юу, юугаар бүтээсэн бэ?

---

---

2. Хүүгийн бүтээсэн найзын нэрийг бичье.

---

---

---

---

---

---


## Мод ус хоёр



Нэгэн сайхан уултай, модтой,  
гол устай нутаг байжээ.



Нэг хүн голын эхэнд ургасан  
модыг огтлоод гал түлж орхижээ.



Гэтэл голын ус ширгэж, тэр нутаг  
усгүй болжээ. Хүн амьтан ч ангаж  
цангаж амьдрах аргагүй болж  
гэнэ.



Харин тэгтэл нэг ачит хүн голын  
эхэнд мод тарьж, моднууд  
олноороо ургаж эхэлжээ. Гол ч  
урсаж эхэлж гэнэ.


Тэр цагаас хойш голын эхэнд ургасан модыг хайрлан хамгаалах болжээ.



Уншсанаа ярилцъя

- Голын ус яагаад ширгэсэн бэ?
- Гол яагаад сэргэсэн бэ?

### 1. Хүний хийсэн үйлийг ялган бичье.



түлсэн, ширгэсэн,  
цангасан, ургасан,  
тарьсан



## Ус

Ус бургин урсдаг  
 Унд тэжээл болдог  
 Уур болон дэгддэг  
 Огторгуйд нисээд гардаг  
 Үүл болоод хувирдаг  
 Бороо болоод шаагьдаг  
 Бут бургасыг ургуулдаг  
 Цас болоод шуурдаг  
 Цагаан дэлхий болгодог  
 Мөс болоод хөлддөг  
 Мөнгө шиг гялтганадаг

Ц.Дамдинсүрэн

1. Усны ашиг тусыг ярилцъя.
2. Усны хувирлыг бичье.



3. Үсгийг эвлүүлж үг бүтээж, утгыг ярилцъя.

5	4	2	1	3
г	а	у	б	л

5	3	4	1	2
й	л	а	д	а

4. Үгсийг эвлүүлж, сургаал үг бүтээе.

Усан	далай	булгаас	эхтэй.
.....	.....	.....	.....

далай, эхтэй, Ухаан, номоос

Ойлгож уншъя.

## Зургийн дэвтэр

Би дэвтрээ дэлгэж байгаад  
Дэлбээгээ дэлгэж байгаа цэцэг зурлаа

Дүү дэвтэрт минь  
Ариун цэцгэн дээр  
Эргэлдэн нисэг гэж  
Эрвээхэй зурлаа

Эгч энэ хоёрыг нь  
Шаргал туяагаараа  
Гэрэлтүүлэг гэж  
Нар зурлаа

Ах дэвтрийг минь  
Ажиглаж хараад  
Зугаатай цэнгэлтэй  
Зуны улирал  
Зурж өглөө

Би хүчээ нийлүүлж  
Хамтарч чадвал  
Хүссэн бүхнээ  
Хийж болдгийг мэдлээ

3.Жаргалсайхан


1. Зурагт юу нэмж зурж болох вэ?

2. Өгүүлбэр бүтээж уншъя.

Хэн?	юу?	яасан бэ?
Би	цэцэг	зурсан
Ах		
Эгч		

Зөв бичье

эрвээхэй, болдгийг



Уншсанаа ярилцъя

- Хэн хэн юу зурсан бэ?
- Хүү юу ойлгосон бэ?

## Сониуч янзага



Бяцхан янзага цас орж байхыг хараад “Энэ юу вэ?” гэж ээжээсээ асуув.



Ээж нь “цас” гэж хэлээд цасны тухай ярив.



Дараа нь зуны тухай ярьж өгөв.



Би цэцэг хармаар байна гэхэд, “Цаг нь болохоор хараарай” гэж ээж нь аргадлаа.



Хавар боллоо. Янзага ойн амьтадтай тоглон баяртай байлаа.



Гэтэл цасан доороос нэг зүйл цухуйж байхыг олж харав .....



## Бяцхан бөөдий

Нэг өдөр бяцхан бөөдий ээжээсээ:  
- Би ямар зараа вэ? Сайн уу? Муу юу?  
гэж асуув.

Мэлхий:

- Чи тун сайн зараа. Яагаад гэвэл  
намайг “Вааг, вааг” гэж дуулж байхад чи  
алгаа ташиж байсан шүү дээ” гэв.



Үнэг:

- Чи муу шүү дээ. Чиний өргөснүүд  
чинь намайг хатгасан гэв.

Шоргоолж:

- Үнэгэнд битгий итгэ! Бөөдий чи сайн  
шүү дээ. Намайг нуруун дээрээ суулгаж  
гол гаргаж өгсөн гэв.



Хэдгэнэ:

- Зараа муу амьтан. Намайг цэцгээс сэгсэрч  
газар унагасан гэв.

Галууны дэгдээхэй:

- Үгүй үгүй, Тэр худлаа. Бөөдий чи бол сайн.  
Намайг өвсөн дотор төөрчихсөн байхад ус руу  
оруулж өгсөн гэв.






Хэрэм:

- Бөөдий муу, тэр миний хатаасан самрыг аваад явчихсан юм гэв.

Бөжин:

- Намайг унтаж байхад над руу гэтэж явсан үнэгийг хөөж тусалсан. Бөөдий бол тун сайн гэв.



Хулгана:

- Миний хөөөг эвдсэн бөөдий муу! гэв.

Ингэхээр би чинь ямар амьтан бэ? гэж бөөдий ээжээсээ асуув.

Ээж нь:

- Чи хэн нэгнийг гомдоовол муу. Харин үргэлж бусдыг баярлуулж тус болж байвал л сайн гэж хэлэв. Яг зөв шүү дээ гэж бүх амьтад ээжийг нь дэмжив.



Уншсанаа ярилцъя

Зарааг магтсан, муу хэлсэн амьтдын нэрийг ялган бичье.

Бөөдий бол **сайн**

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

???



Бөөдий бол **муу**

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

Ээжийнх нь хэлсэн үгтэй санал нийлж байна уу? Ярилцъя.

1. Амьтдыг төлөөлөн уншъя.

2. Нэг амьтныг сонгон, түүний хэлсэн өгүүлбэрийг бичье.

Зөв бичье

дэгдээхэй, хөөө

## Яст мэлхий, туулай хоёр



Туулай:

- Яст мэлхий! Хоёулаа тэр довны орой дээр сагстай жимс тавиад уралдъя. Хэн түрүүлсэн нь жимсээ идье” гэж гэнэ. Яст мэлхий жаахан бодсоноо зөвшөөрчээ.



Тэгээд яст мэлхийг “За тэгвэл одоо уралдъя” гэхэд туулай инээдээ барьж ядан гараанаас зэрэг хөдлөв.



Туулай яст мэлхийг хол орхин давхлаа. Хэдийгээр яст мэлхий туулайг гүйцэж чадахгүй гэдгээ мэдэж байсан ч сагстай жимс байгаа газар руу хамаг чадлаараа явсаар байв.



Туулай эргэж харснаа яст мэлхийг мөд гүйцэхгүй гэж бодоод унтаад өгөв. Энэ хооронд яст мэлхий туулайг гүйцэж, хажуугаар нь явж өнгөрөв.

**Зөв бичье**

уралдъя, идье





Туулайг сэрээд хартал яст мэлхий жимсэнд тун ойртон очсон харагдав.



Яст мэлхий зогсолтгүй явсаар хүрэх газраа хүрсэн байна. Харин бардам туулай хэтэрхий сайрхаж байгаад юу ч үгүй хоосон хоцорсон нь энэ.



Уншсанаа ярилцъя

- Туулай яагаад түрүүлж чадаагүй вэ?
- Яст мэлхий юуны хүчээр түрүүлэв?
- Үлгэрээс юу сурч авав?

### 1. Туулайд юу гэж хэлэхээ бичье.

Яст мэлхийд

Чи хичээж зогсохгүй явсны хүчинд түрүүлж чадлаа. Энэ зангаа орхиж болохгүй.

Туулайд

---

---

---

---

Зөв бичье

зогсолтгүй, хэтэрхий

## Өвдөгцөө



1. Өндөр гэгчийн хөх тэмээ  
Гол гатлаад гарч явж  
Өөдөөс нь тэгтэл нэг ямаа  
Зам дөтлөөд хүрээд ирж



2. - Гарч болох уу, үүгээр? гэж  
Сэлмэн эвэрт майлан асууж  
- Гайгүй, өвдөгцөө л юм байна гэж  
Ширээ бөхт буйлан хариулж



3. Үерлэсэн гол руу өнөө ямаа  
Үгийн хариугүй шоволзоод орж  
Эргэлдсэн усанд хөл алдаж  
Эврийнх нь үзүүр цухалзаад ирж



4. Ам хамар нь ангалзах тоолонгоор  
- Амь авар гээд бархирч байж  
Урт хүзүүгээ тэмээ сунгаад  
Усны эрэгт татаж гаргаж

Утгыг мэдье

дөтлөх, өвдөгцөө

Зөв бичье

шоволзоод, эргэлдсэн

5. Эвэр далдрам цүнхээл усыг  
Өвдөгцөө гэж дэгсдүүлдэг  
Эргүү тэнэг мал уу чи гээд л  
Сахалт ямаа омогдож гарч



6. Атан тэмээ тоосон шинжгүй  
Алсын бараа ширтэн зогсоно  
Тэмээ гэдэг тэмээ л юм даа  
Ямаа гэдэг ямаа л юм даа  
*Ж.Дашдондог*



Уншсанаа ярилцъя

- Ямаа ямар зангаасаа болж ямаа усанд унасан бэ?
- Үлгэрээс юу сурч авсан бэ?

1. Тэмээнд бичсэн зөвлөгөөг уншаарай. Тэгээд ямаанд хандаж зөвлөгөө бичье.

Тэмээнд

Тэмээ чи, өөрөөсөө намхан ямаанд голын усыг “өвдөгцөө” гэж хэлсэн. Харин ямаанаас яах гэж байгааг нь асуух хэрэгтэй байсан юм. Тэгсэн бол ямаа ус руу шууд орохгүй байсан даа.

Ямаанд

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Утгыг мэдье

цүнхээл, дэгсдүүлэх, сэлмэн эвэрт, ширээ бөхт

## Марал эх зохиож бичсэн нь

1. Маралын ангийн сурагчид эх зохиож бичих болжээ. Марал юу бичихээ удаан бодлоо. Тэгээд хөдөө явсан тухайгаа бичих болжээ. Тэгээд нэг зураг зуржээ.



2. Марал зургаа үзээд хамгийн чухал зүйлийг дутуу зурснаа саналаа. Тэр ааруул идэх их дуртай тул дэлгэцтэй ааруул нэмж зурлаа.



### Өөрсдөө хийгээрэй.

1. Юуны тухай бичихээ бодоорой. Бичихийн өмнө зураг зурж болно.

2. Зургаа үзээд, дутуу зүйлийг нэмж зураарай.



3. Марал зургаа дахин сайн харав. Тэгээд зургаас санаа авч “Ааруул” гэсэн эх зохиожээ.



Ааруул  
Би эмээ дээрээ огсон. Эмээ  
эх амилтай. Үнээ саана. Марал  
бүрэнэ. Үнээ саана. Ааруул хий  
дэл. Би ааруул идэх дуртай.

4. Марал зохиосон эхээ найз Маргадад уншиж өгөв. Маргад түүнээс “Тэр амттай ааруулыг хэн хийдэг вэ?” гэж асуув. Марал эмээгээ амттай ааруул тавьдаг тухай нэмж бичив.



Ааруул  
Би эмээ дээрээ огсон. Эмээ  
эх амилтай. Үнээ саана. Марал  
бүрэнэ. Үнээ саана. Ааруул хий  
дэл. Би ааруул идэх дуртай.  
Эмээгийн ааруул амттай.

### Өөрсдөө хийгээрэй.

3. Зургаа хараад эх зохиож бичээрэй.
4. Бичсэн эхээ найздаа уншиж өгөөрэй. Дараа нь орхисон зүйлээ нэмж бичээрэй.



5. Марал бичсэнээ аав ээждээ уншиж өгөв. Тэдэнтэй хамтарч бага зэрэг засвар хийв.

Ааруу  
Би зун зун дээрээ орсон. Зунээ  
и эх амжилтай. Үнээ саана. Марал тавина.  
бурэнэ. Үнээ саана. Ааруу хий  
дэг. Би ааруу идэх дуртай.  
Зунгийн ааруу амттай.

6. Марал шинэ цаасан дээр зохиосон эхээ хуулж бичив. Ангийн самбарт зурсан зураг, зохиосон эхээ байрлуулав. Сурагчид бүтээлээ харилцан үзэж, бие биедээ уншиж өгөв.



Ааруу  
Би зун зун дээрээ орсон. Миний  
зун эх амжилтай. Үнээ саана.  
Марал бурна. Ааруу тавина.  
Зунгийн ааруу их амттай.

Ааруу  
Би зун зун зун дээрээ орсон. Миний  
зун эх амжилтай. Үнээ саана.  
Марал бурна. Ааруу тавина.  
Зунгийн ааруу их амттай.

### Өөрсдөө хийгээрэй.

5. Бичсэн эхээ хэн нэгэнд уншиж өгөөрэй. Алдаа байвал хамтарч засаарай.

6. Цэвэрхэн цаасан дээр дахин бичээрэй.



## Дэлбээ цэцэг хоёр

Цэцгийн мандалд нэгэн гоё цэцэг ургажээ. Дээгүүр нь хэдгэнэ зөгий эргэлдэн шүүсээр нь хооллоно. Гэтэл нэг дэлбээ нь “Би цэцгээс хамгийн сайхан нь. Надгүйгээр цэцэг юу ч биш” гээд газар үсрэн бууж, холдон холдон явжээ. Тэгээд шоргоолжтой тааралдав. Шоргоолж

- Чи хэн гэгч вэ? гэхэд

- Би дэлбээ байна. Би цэцгээс хамгийн сайхан нь. Надгүйгээр цэцэг юу ч биш гэв. Шоргоолж:

- Дэлбээ гэнэ ээ? Би цэцгийн дэлбээг мэднэ. Харин ийм нарийхан хөлтэй дэлбээг хараагүй юм байна гэжээ.

Дэлбээ цааш явсаар байв. Орой болоход хатаж эхэлжээ. Харин цэцэг цэцэглэсээр л байв.

Нэг дэлбээ дутуу ч цэцэг бол цэцэг хэвээрээ. Харин цэцэггүй дэлбээ гэж юу байх билээ.

*В.А.Сухомлинский*

### 1. Дэлбээ яагаад хатсан бэ?

Зөв хариултыг олъё.

а. орой болсон учраас

б. цэцгээсээ салсан учраас

### 2. Зөв холбож, өгүүлбэр бүтээе.



Цэцэггүй дэлбээ

цэцэг мөн

Нэг дэлбээгүй цэцэг

цэцэг биш

### 3. Асуултад тохирох үгсийг ялган будъя.




4. Тулгуур үгийг ашиглан цэцэг тарих зааврыг гүйцээж бичье.  
суулгана, үндэслүүлнэ, усална

Цэцгээс хэсэглэн авч .....

Цэцгийн саванд шороо хийж түүнд .....

Өдөр бүр .....

5. Орхигдсон үсгийг нөхөж бичье.



6. Зургийг ажиглан өгүүлбэрийг гүйцээж, эх бүтээе.



### Авьяастай хүүхдүүд

... гитар хөгжим тоглов. Энхжин ... үлээдэг.  
Номин ... хөгжмөөр хөгжимдлөө. Сувдаа ... хөгжмөө  
эгшиглүүлнэ. Харин ... дуучин охин. Энэ хүүхдүүд үнэхээр  
авьяастай юм аа.




## Мэдлэгийн санд

### Онъсого

Алтан шар бөмбөг  
Агаар тэнгэрээр өнхөрнө



Мөсөн дээр  
Мөнгөн аяга



Жин торго захгүй  
Жижиг сувд нүхгүй




Хөлгүй байж явдаг  
Нүдгүй байж уйлдаг



Тал дээрх долоон торгыг  
Чи ч авч чадахгүй  
Би ч авч чадахгүй



Зуны өдөр зөөлөн биетэй  
Өвлийн өдөр хатуу биетэй




Газрын гадас  
Ганц хөлтэй эмбүү



## Мэдлэгийн санд

### Ертөнцийн гурав

Тэнгэр одоор баян  
Далай усаар баян  
Газар үндсээр баян



Урсахдаа ус хөнгөн  
Хийсэхдээ өд хөнгөн  
Өргөхөд өвс хөнгөн

Ургаж байгаа арц нэг ариун  
Уугьж байгаа хүж нэг ариун  
Урсаж байгаа гол нэг ариун



Идээний эх цай  
Эдийн эх хадаг  
Амьтны эх загас



Холоос харагдаж байгаа уул нэг цэнхэр  
Хонхорт тогтсон ус нэг цэнхэр  
Хорвоод байгаа тэнгэр нэг цэнхэр



## Мэдлэгийн санд

### Зүйр цэцэн үг



Аавын сургаал алт  
Ээжийн сургаал эрдэм

Ангир уургийг ээжээс  
А-үсгийг багшаас

Эрхийг сурахаар  
Бэрхийг сур



Алтан дэлхийг нар гийгүүлдэг  
Ард түмнийг эрдэм гийгүүлдэг

Хүн болох багаасаа  
Хүлэг болох унаганаасаа

Эрдмийг эхнээс нь  
Эвийг эртхэнээс


Эрдэмтэй хүн даруу  
Их мөрөн дөлгөөн

Уншиж мэдэхэд ном сайхан  
Уулзаж ярихад нөхөр сайхан

Ачийг ачаар  
Тусыг тусаар

Ном уншихад нойр сэргэнэ  
Тоо бодоход толгой сэргэнэ





## ГАРЧИГ

Бэлтгэл хэсэг .....	3-22
Эгшиг үсэг (а, э, и, о, у, ө, ү) .....	23-42
I шатны гийгүүлэгч (м, с, р, х, в, л, н, ш) .....	43-76
II шатны гийгүүлэгч (д, б, г, т, ц, ч, з, ж) .....	77-110
я-гийн төрлийн үсэг ба онцгой гийгүүлэгч (я, е, ё, ъ, ю, п, к, ф, щ).....	111-128
Цагаан толгойн дараах үе .....	129-171